ИЗДын 1993 оны А282-р захирамжаар хүчингүй.

УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

# ТОГТООЛ

1986 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 227

Улаанбаатар хот

Гуанзууд шинээр нээж харъяалал тогтоох тухай

БНМАУ-ын Хөдөлмөр, нийгэм хангамжийн улсын хороо, Хөнгөн ба хүнсний үйлдвэрийн яамдын санал хүсэлтийг харгалзан Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1.БНМАУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 1986 оны төлөвлөгөөний дагуу баригдан ашиглалтанд орж байгаа Хөдөлмөр,нийгэм хангамжийн улсын хорооны харъяа хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийн ажилчдын зориулалттай 150 хүний суудалтай гуанзыг Октябрийн районы нийтийн хоолны трестэд, хөнгөн ба хүнсний үйлдвэрийн яамны биеийн тамир спортын "Хөдөлмөр" нийгэмлэгийн "Тамирчин" зочид буудлын 60 хүний суудалтай гуанзыг Ажилчны районы нийтийн хоолны трестэд тус тус харъяалуулж,1987 оны I дүгээр сарын I-нээс эхлэн нээж ажиллуулахыг хотын нийтийн хоолны удирдах газар /н.Урианхай/-т даалгасугай.

2.Шинээр нээгдэж байгаа гуанзуудад ажиллах хүмүүсийн орон тоог нормативаар баталж өгөхийг хотын санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/, шаардагдах барааны фонд, төлөвлөгөөг нийтийн хоолны удирдах газрын 1987 оны барааны фонд, төлөвлөгөөнд нэмэгдүүлэн баталж өгөхийг хотын төлөвлөгөөний комиссын орлогч дарга н.Ганбаатарт даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА С.МӨНХЖАРГАЛ

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ч.ЖАМБАЛ